

зуухтайгаа ойролцоо өндөртэйгөөр хийсэн яндантайгаа холбож бэхэлснээр био нүүрсний зуух бэлэн болно. Зураг 3.


Био нүүрс хийнэ гэдэг нь аливаа өтөг, бууц, мод, түлээ гэх мэт органик биетүүдийг хүчилтөрөгчгүй эсвэл маш бага хүчилтөрөгчтэй орчинд өндөр хэмээр халааж доторхи усыг бусад шатамхай хийнүүдийн хамт уршуулан ялгаж хуурай, хар өнгийн хатуу



Зураг 4. Био нүүрс хийж байгаа нь

үлдэгдэл (charcoal) гаргаж авахыг хэлнэ. Энэ үед био нүүрсны зуух метан зэрэг шатамхай хийнүүдийг давхар шатааж халаалтандаа ашиглах бөгөөд нүүрстөрөгч нь био нүүрсэндээ үлддэг байна.

Хэрэв шатаалтыг илбүү хуучилтөрөгчтэй орчинд явуулбал нүүрстөрөгч нь агаарт дэгддэг тул био нүүрсийг битүү саванд хийдэг байна. Био нүүрсийг гарган авахдаа өтөг бууцыг зуухандаа хийж дээрээс нь гал өгч таглаад 350-700 хэм халуунд шатаана. Зураг 4. Өтөг бууцны хэмжээ, чийгшилтээс хамааруулан 20 минутаас 1 цаг хүртэл хугацаагаар шатаасны дараа тагийг авч хүйтэн усаар шүршиж бүрэн унтрааснаар био нүүрс бэлэн болно. 36 кг түүхий эдээс ойролцоогоор 10 кг био нүүрс гарах бөгөөд түүнийгээ тусгайлан бэлтгэсэн тавиур дээр дэлгэж хатаагаад савлана.



Алт олборлолтод мөнгөн усыг хэрэглэмээс гаргах төсөлд хамрагдагсад зориулалт

МАЛЫН ӨТӨГ, БУУЦААР БИО НҮҮРС ХИЙХ гарын авлага

Манай хаяг: Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн Жижиг Төслийн Хөтөлбөр, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, НҮБ-ын байр, НҮБ-ын гудамж-14, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14201, Монгол улс.
Утас: 70112883

Цахим шуудан: ganbaatar.bandii@undp.org
naran@arav.gankhuuyag@undp.org

Био нүүрс гэж юу вэ?



Зураг 1. Био нүүрс

Био нүүрс гэж мал, амьтны гаралтай хуурай органик түүхий эдийг агааргүй орчинд халаах пиролиз буюу нэрэх аргаар гарган авсан ус, агаар шингээх нүх сүвтэй, сэвсгэр нунтаг нүүрсийг хэлнэ. Зураг 1. Био нүүрсийг төрөл бүрийн модны хаягдал, үртэс, малын өтөг, бууц, аргал, шувууны сангас, малын яс, самрын боргоцой гэх мэт органик түүхий эдээс гарган авч болох боловч манай орны хувьд хамгийн тохиромжтой түүхий эд бол малын өтөг, бууц юм.

Ямар ач холбогдолтой вэ?

Био нүүрсийг газар тариалан, эрчим хүч, мал эмнэлэг, анагаах ухааны салбарт өргөн ашиглаж байна. Био нүүрс нь хөрсний ус, шим тэжээлийг тогтоон хадгалахад тус дэм үзүүлэх

нунтаг, сийрэг, нүхэрхэг бие бүтэцтэй, түүнд агуулагддаг нүүрстөрөгч нь хөрсөнд 1000 хүртэл жил хадгалагдах тул доройтолд орсон хуурай цөлөрхөг хөрсийг ургамалжуулахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Био нүүрс химийн бордоо биш боловч хөрсний бүтцийг сайжруулж, хөрсний микроорганизмуудынамыдралыгтэтгэх чадвартай органик идэвхижүүлэгч юм. Түүнийг хөрсөнд холиод 1 удаа услахад 60-70 хоног чийгээ барьж чаддаг. 1 грамм хөрсөнд 3 сая ширхэг ашигтай бактери байдаг бол био нүүрс холиод 30 хоногийн дараа үзэхэд 300 сая ширхэг буюу 100 дахин нэмэгдэж байжээ. Мөн төмс, хүнсний ногооны тариалалтад түршиж үзэхэд гарц нь 40 хүртэл хувиар нэмэгдэж байжээ. Дэлхий нийтэд био нүүрсийг ус цэвэршүүлэгч, агаар шүүгч, хүн малын нүүрсэн эм, малын бордоо, үнэр шингээгч гээд олон бүтээгдэхүүнд түүхий эд болгон ашиглаж байна.

Хэрхэн хийх вэ?

Био нүүрс хийх олон төрлийн арга замууд, тэдгээртээ тохирсон зүүхнүүд байдгаас хамгийн энгийн зүүх болох манайхны “200 литрийн пойшиг” гэж ярьж хэвшсэн төмөр лаазаар хийсэн зүүхыг ашигладаг аргыг танилцуулж байна. Зүүхыг хийхдээ

эхлээд лаазныхаа ёроол талыг нь олон нүхнүүд гарган цоолно. Зураг 2. Харин дээд буюу амсар талыг нь таглаа болгон ашиглах байдлаар тасдан авч гол хэсэгт нь яндангийн нүх гаргана. Эцэст нь



Зураг 2. Ёроолыг цоолсон байдал



Зураг 3. Био нүүрс хийх зүүх